



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 270

Мандалговь

Хөрөнгө дахин үнэлж худалдах тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 6.3.3 дах заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**


1. Сайнцагаан сумын Наран багийн склад, моторын граж, Баянжаргалан сумын ИТХ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ISUZU маркын 41-89 ДУА улсын дугаартай автомашиныг дуудлага худалдаагаар худалдах доод үнийг 50 хувиар буулган хавсралтын дагуу худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 07 сарын 04-ний өдрийн 218 тоот “Хөрөнгөд үнэлгээ тогтоох тухай” тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ



Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 11 сарын
21 өдрийн 270-р тогтоолын хавсралт

Барилга байгууламжийг худалдах үнэ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Талбай	Хуучин үнэ	Бууруулсан дүн 50%	Худалдах үнэ
1	Наран чулуун склад	1957	м ²	52.95	544'000	272'000	272'000
2	Наран моторын граж	1957	м ²	20.14	76'800	38'400	38'400
ДҮН					620'800	310'400	310'400

Тээврийн хэрэгслийн худалдах үнэ

№	Хөрөнгийн нэр	Тээврийн хэрэгслийн марк	Улсын дугаар	Үйлдвэр лэсэн он	Хуучин үнэ	Бууруулсан дүн 50%	Худалдах үнэ
1	Баянжаргалан автомашин	Isuzu Big horn	Дуа 41-89	2001	4'480'000	2'240'000	2'240'000
ДҮН					4'480'000	2'240'000	2'240'000